

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тээлийн илч ОНӨААТҮГ-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/014/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: М.Энхжаргал

Утас: 70432545 Цахим хаяг: Enkhjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	7
3.1 ЗӨВЛӨМЖ	7
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9
5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.03.13 № 250

танай _____-ны № _____-г

ТЭЭЛИЙН ИЛЧ ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ДАРГА Д.НЯМ-ОЧИР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Ховд аймгийн Зэрэг сумын Тээлийн илч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 14.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд уг алдагдал үүсэхэд борлуулалтын орлого төлөвлөсөн хэмжээнд бүрдүүлээгүй, зарим авлага дутуу төвлөрүүлсэн, зардлын хяналт сул байсан зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тээлийн илч" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2025 оны орлого, зардлын төлөвлөгөө, зорилтот түвшинг Зэрэг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаар хурлын тогтоолоор борлуулалтын орлогыг 631.8 сая төгрөгөөр, зарлагыг 671.0 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

8426050605

Бусад асуудлын хэсэг

Тээлийн илч Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын бүтэц, орон тоог сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн хурлаар 21 орон тоотойгоор ажиллахаар баталж, гүйцэтгэлээр 23 орон тоотой ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,393,067.66	81,620,658.44
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	59,192,007.66	31,346,954.14
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	59,192,007.66	31,346,954.14
31210	Төгрөг	59,192,007.66	31,346,954.14
31213	Арилжааны банк дахь харилцах	59,192,007.66	31,346,954.14
33	АВЛАГА	116,790.00	2,190,484.58
33401	Дансны авлага /ТӨҮГ/	15,487.00	1,593,451.01
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	101,303.00	597,033.57
35	БАРАА МАТЕРИАЛ	31,084,270.00	48,083,219.72
35400	Хангамжийн материал	31,084,270.00	48,083,219.72
35420	Аж ахуйн материал	11,366,000.00	12,494,636.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,243,000.00	3,112,835.78
35440	Түлш, шатах тослох материал	15,648,500.00	25,696,477.94
35470	Бусад хангамжийн материал	2,826,770.00	6,779,270.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,854,700.00	6,369,600.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,854,700.00	6,369,600.00
39200	Биет хөрөнгө	6,854,700.00	6,369,600.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,367,000.00	3,367,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	673,400.00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,061,000.00	8,441,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	4,573,300.00	4,765,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	97,247,767.66	87,990,258.44
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	8,260,636.00	12,011,127.33
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	8,260,636.00	12,011,127.33
41300	Өглөг	8,260,636.00	12,011,127.33
41360	Бусад өглөг	8,260,636.00	12,011,127.33
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	8,260,636.00	12,011,127.33
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	88,987,131.66	75,979,131.11
51	Засгийн газрын хувь оролцоо	88,987,131.66	75,979,131.11
51200	Хуримтлагдсан үр дүн	88,987,131.66	75,979,131.11
51210	Өмнөх үеийн үр дүн	38,397,201.81	90,120,331.66
51220	Тайлант үеийн үр дүн	50,589,929.85	14,141,200.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	97,247,767.66	87,990,258.44

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	51,396,029.85	- 12,142,900.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,396,029.85	- 12,142,900.55
120	Нийтлэг татварын бус орлого	51,396,029.85	- 12,142,900.55
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	560,200,884.83	577,372,281.08
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	508,804,854.98	589,515,181.63
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	806,100.00	1,998,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	806,100.00	1,998,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	806,100.00	1,998,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	806,100.00	1,998,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	806,100.00	1,998,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	50,589,929.85	- 14,141,200.55
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	50,589,929.85	- 14,141,200.55

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38,397,201.81	38,397,201.81
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,397,201.81	38,397,201.81
9	Тайлант үеийн үр дүн	50,589,929.85	50,589,929.85
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,987,131.66	88,987,131.66
11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	88,987,131.66	88,987,131.66
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,133,200.00	1,133,200.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	90,120,331.66	90,120,331.66
19	Тайлант үеийн үр дүн	- 14,141,200.55	- 14,141,200.55
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	75,979,131.11	75,979,131.11

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	570,200,884.83	633,792,128.27
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	570,200,884.83	633,792,128.27
120	Нийтлэг татварын бус орлого	570,200,884.83	633,792,128.27
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	570,200,884.83	633,792,128.27
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	523,275,431.10	661,637,181.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	523,275,431.10	661,637,181.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	523,275,431.10	661,637,181.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,416,300.00	339,045,732.00
210101	Үндсэн цалин	260,416,300.00	-
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	-	339,045,732.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,921,597.00	-
210201	Тэтгэврийн даатгалын зардал	29,921,597.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,324,865.01	162,279,066.54
210301	Гэрэл, цахилгаан	36,771,916.56	-
210302	Түлш, халаалт	65,975,000.00	-
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	70,577,948.45	162,279,066.54
2104	Хангамж, бараа материалын зардал	17,048,400.00	62,375,225.00
210402	Тээвэр, шатахуун	17,048,400.00	-
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	-	48,630,225.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	-	13,745,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	97,937,158.25
210817	Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	49,981,916.25
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	-	47,955,242.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,564,269.09	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,564,269.09	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	46,925,453.73	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	4,217,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,217,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	4,217,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,217,000.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	- 4,217,000.00	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	42,708,453.73	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	16,483,553.93	59,192,007.66
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	59,192,007.66	31,346,954.14

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 15,971.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 9,928.9 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг залруулж, баталгаажуулав. Үүнд:

- ✓ Санхүүгийн тайланг үнэн зөв иж бүрэн гаргаагүй, авлага дутуу бүртгэсэн, үндсэн хөрөнгийн элэгдэл буруу бодсон тайлант хугацааны үр дүн зөрүүтэй тайлагнасан, эргэлийн хөрөнгийн шинж чанартай бараа материалыг шууд зардалд бүртгэсэн 9,928.9 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй 6,042.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчилд 6,042.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

3.1 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.1.1 Анхан шатны баримтын бүрдэл, бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээнд ашиглалтын талбайн хэмжээг (м²) бодит байдлаас зөрүүтэй тусгасны улмаас 6,042.2 мянган төгрөгийн орлогын зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулж буй гэрээнд тусгасан ашиглалтын талбайн хэмжээг бодит хэмжилтэд тулгуурлан дахин тооцож, гэрээний нөхцөлийг шинэчлэн баталгаажуулж, цаашид орлого дутуу төвлөрөх эрсдэлийг арилгах.

3.1.2 Цалингийн нэмэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНӨААТҮГ-ын албан хаагчдад сумын Засаг даргын болон байгууллагын даргын тушаалаар орон нутгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам”-ын 1.1-т “Төрийн албан хаагчдыг орон нутагт ажиллах сонирхлыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор төрийн

захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгоход энэ журмыг баримтална.” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид орон нутгийн нэмэгдлийг зөвхөн хуульд заасан этгээдэд олгох.

3.1.3 Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө, зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасан хугацаанд холбогдох мэдээллийг үнэн зөв байршуулан Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							тоо	Дүн	тоо	Дүн		
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв, иж бүрэн гаргаагүй байх	1	9,928.9			1	9,928.9	1	9,928.9				
ДҮН	1	9,928.9	0	0.0	1	9,928.9	1	9,928.9				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
Аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээнд тусгасан ашиглалтын талбайн (м ²) хэмжээнд бодит ашиглалттай уялдуулан хянаагүй нь	1	6,042.2						1	6,042.20	
Хууль тогтоомжид нийцээгүй орон нутгийн нэмэгдэл олгосон	1							1		
ДҮН	3	6,042.20	0	0	0	0	3	6,042.20	0	0

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10
Тээлийн илч ОНӨААТҮГ	Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээлээгүй	1	0	0	0	0	0	1	0
Нийт дүн		1	0	0	0	0	0	1	0

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			